МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 23 өдөр Дугаар А/62 Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт, төсөвт
өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 03 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Хөвсгөл, Жаргалант, Галт, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант сум) "Сэрээт ергөгч, хүнсний зориулалттай модон сав" худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсоргодог)-т даалгасугай.

3. Дээрх сумдад шаардлагатай теник хэрэгсэлийг худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Захирамж-2022

Аймгийн Засаг даргын 2022 оны 02
дугаар сарын 2.. өдрийн А/.62 дугаар
захирамжийн хавсралт

"БАГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР"-ИЙН ХҮРЭЭНД
/ХӨВСГӨЛ, ЖАРГАЛАНТ, ГАЛТ, ТӨМӨРБУЛАГ, ТОСОНЦЭНГЭЛ,
ИХ-УУЛ, РАШААНТ СУМ/ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР
2022 ОНД СЭРЭЭТ ӨРГӨГЧ, ХҮНСНИЙ ЗОРИУЛАЛТТАЙ
МОДОН САВ ХУДАЛДАН АВАХ АЖЛЫН ЖАГСААЛТ,

ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Үйл ажиллагаа	Тоо ширхэг	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Сэрээт өргөгч	1	40,000,000
2	Хүнсний зориулалтай модон сав худалдан авах	148	67,700,000
Нийт дүн			**107,700,000**

_____oOo_____